



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 207

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 17 нэрийн, нийт 83,698,482.00 (наян гурван сая зургаан зуун ерэн найман мянга дөрвөн зуун наян хоёр) төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 8,369,848.20 (найман сая гурван зуун жаран есөн мянга найман зуун дөчин найман төгрөг хорин мөнгө) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал М.Түмэнжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2022 оны 05 дугаар сарын-ны өдрийн
 дугаар тогтоолын хавсралт

**"Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨААТҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, үлдэх өртөггүй
 хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох хөрөнгийн жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үнэ болон хугацааг шинэчлэн тогтоох			
						Тоо хэмжээ	Ашиглах хугацаа /жилээр/	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	434 3 фазын энерги	2018-08-20	1	22,000,000.00	22,000,000.00	1	2	2,200,000.00	2,200,000.00
2	EXETECH 3000A 3 фазын хэмжилтийн багаж	2018-08-20	1	14,190,000.00	14,190,000.00	1	2	1,419,000.00	1,419,000.00
3	GRAPHEC midi Logger GL 240 багаж	2018-08-20	1	3,410,000.00	3,410,000.00	1	2	341,000.00	341,000.00
4	Босоо эйр кондишн	2018-10-15	1	2,903,000.00	2,903,000.00	1	2	290,300.00	290,300.00
5	Халуун хөшиг	2018-10-15	1	709,900.00	709,900.00	1	2	70,990.00	70,990.00
6	HP MFP M130FN	2017-10-20	1	589,400.00	589,400.00	1	2	58,940.00	58,940.00
7	Телевизор 43инч	2018-10-15	1	950,000.00	950,000.00	1	2	95,000.00	95,000.00
8	Зургийн аппарат Canon SX-60	2018-07-30	1	1,200,000.00	1,200,000.00	1	2	120,000.00	120,000.00

9	Dell суурин компьютер 1050	2018-11-12	1	3,043,008.00	3,043,008.00	1	2	304,300.80	304,300.80
10	Dell суурин компьютер 3670MT	2018-11-12	6	1,775,808.00	10,654,848.00	6	2	177,580.80	1,065,484.80
11	HP-принтер	2018-11-12	2	543,663.00	1,087,326.00	2	2	54,366.30	108,732.60
12	Гадна камер HFV4431 TP-4MP	2018-10-08	3	275,000.00	825,000.00	3	2	27,500.00	82,500.00
13	Дотор камер HDBW1420EP-4MP	2018-10-08	6	182,000.00	1,092,000.00	6	2	18,200.00	109,200.00
14	Техөөрөмж NV R4216 16 channel	2018-10-08	1	494,000.00	494,000.00	1	2	49,400.00	49,400.00
15	Hard disk 4 TB	2018-10-08	1	550,000.00	550,000.00	1	2	55,000.00	55,000.00
16	Юникус санхүүгийн программ	2018-01-01	1	5,000,000.00	5,000,000.00	1	2	500,000.00	500,000.00
17	Loss 0.4 /зураг төслийн программ/	2018-04-16	1	15,000,000.00	15,000,000.00	1	2	1,500,000.00	1,500,000.00
					83,698,482.00				8,369,848.20
НИЙТ ДҮН					(наян гурван сая зургаан зуун ерэн найман мянга дөрвөн зуун наян хоёр)				(найман сая гурван зуун жаран есөн мянга найман зуун дөчин найман төгрөг хорин мөнгө)